

БАТЛАВ
ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Т.СҮХБОЛД

2026 оны дугаар сарын -ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ
КОМАНДЛАГЧИЙН НЭРЭМЖИТ, ТӨРИЙН ЦЭРГИЙН БОЛОН ХУУЛЬ
САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
БУУДЛАГЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2026.07.29

Улаанбаатар хот

Зорилго: Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага солилцох, алба хаагчдын буудлагын ур чадварыг дээшлүүлэхэд оршино.

Оролцох байгууллага: Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалах яам, Төрийн тусгай хамгаалалтын газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль зэрэг 13 байгууллагууд оролцоно.

Зохион байгуулагч: Дотоод хэргийн их сургууль

Хугацаа: 2026 оны 09 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд

Тэмцээн зохион байгуулах газар: Хан-Уул дүүрэг, 14-р хороо, Ханангийн ар, Ар хөндлөн. /Ханан-Ар буудлага спорт, сургалтын төв/

Техникийн зөвлөгөөн: 2026 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Дотоод хэргийн их сургуулийн 1 давхрын Эрдэм-3 танхимд болно.

НЭГ. ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ерөнхий шүүгч: Ханан ар буудлага спорт, сургалтын төвийн захирал М.Баярсайхан.

Тэмцээний ерөнхий зохион байгуулагч:

✓ Азийн буудлагын академи, Монголын Гурван бууны болон Төмөр буудлагын холбоо;

✓ Дотоод хэргийн их сургуулийн тэмцээн зохион байгуулах ажлын хэсэг.

Хөндлөнгийн шүүгч:

✓ Байгууллага бүрээс томилогдсон 1 хөндлөнгийн шүүгч шүүгчдийн зөвлөлд орж тэмцээний туршид дасгал бүрт хөндлөнгийн хяналт тавьж, ажиллана. Хяналт тавьж ажиллахдаа тэмцээний явц байдлыг камерын бичлэгээр баримтжуулна;

✓ Аливаа маргаантай асуудал болон гарсан шийдвэрийг тэмдэглэн бүртгэнэ;

✓ Гарсан шийдвэрийн бүртгэл дээр тамирчин болон талбайн шүүгчээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

Тэмцээний төрөл:

- ✓ Хөдөлгөөнт буудлага -3 бууны тэмцээн, 1 ба 3 буу;
- ✓ Цэц буудлага - F ангилал буудлага.

Тэмцээний оролцогч:

- ✓ Гар бууны төрөл: Байгууллага бүрээс 1 баг оролцох бөгөөд баг тус бүр 3 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчдаас бүрдэнэ;
- ✓ Карабин бууны төрөл: Байгууллага бүрээс 1 баг оролцох бөгөөд баг тус бүр 3 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчдаас бүрдэнэ;
- ✓ Цэц буудлагын төрөл: Байгууллага бүрээс 1 албан хаагч оролцоно;
- ✓ Удирдлагын төрөл: Байгууллага бүрээс 1 удирдлага оролцох бөгөөд тухайн байгууллагын дарга эсхүл тэргүүн дэд дарга оролцоно;
- ✓ Тусгай томилгоот нэгжийн төрөл: Тусгай томилгоот нэгжийн албан хаагчдын 1 баг оролцох бөгөөд баг тус бүр хүйс харгалзахгүй 4 тамирчдаас бүрдэнэ.

1. Гар буу/1 Gun

Огноо: Тэмцээний 1 дүгээр өдөр;

Ангилал: Нэмэлт тоноглолгүй, ил харааны хэрэгсэлтэй гар буу;

Шаардлага: Тухайн байгууллагад багадаа сүүлийн 6 сарын хугацаанд томилогдон ажилласан албан хаагч байх; /Тусгай томилгоот нэгжийн алба хаагч оролцохгүй/

Дасгалын тоо: 4;

Сумны тоо, хэмжээ: 130 ширхэг;

Баг: 3 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчдаас бүрдэнэ;

Багийн дүн гарах эсэх: Багийн бүх гишүүдийн дүнгийн дунджаар гарна.

2. Карабин/1 Gun

Огноо: Тэмцээний 1 дүгээр өдөр;

Ангилал: Нэмэлт тоноглолгүй, ил харааны хэрэгсэлтэй карабин, хөл хэрэглэхгүй;

Шаардлага: Тухайн байгууллагад багадаа сүүлийн 6 сарын хугацаанд томилогдон ажилласан албан хаагч байх; /Тусгай томилгоот нэгжийн алба хаагч оролцохгүй/

Дасгалын тоо: 4;

Сумны тоо, хэмжээ: 130 ширхэг;

Баг: 3 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчдаас бүрдэнэ;

Багийн дүн гарах эсэх: Багийн бүх гишүүдийн дүнгийн дунджаар гарна.

3. Цэц буудлага-F Class

Огноо: Тэмцээний 1 дүгээр өдөр;

Ангилал: Гар ажиллагаатай карабин ангилахгүй;

Шаардлага: Тухайн байгууллагад багадаа сүүлийн 6 сарын хугацаанд томилогдон ажилласан албан хаагч байх;

Дасгалын тоо: 2;

Сумны тоо, хэмжээ: 30 ширхэг;

Бай: 600 ба 800 метрт байрлах онооны байг зай бүрт 15 сумаар буудлага хийнэ;

Багийн дүн гарах эсэх: Үгүй;

Гар буу/Шотган 2 Gun-Удирдлагын тэмцээн

Огноо: Тэмцээний 1, 2 дугаар өдөр;

Ангилал: Нэмэлт тоноглолгүй, ил харааны хэрэгсэлтэй гар буу, шотган;

Шаардлага: Байгууллагын дарга эсхүл тэргүүн дэд дарга оролцоно;

Дасгалын тоо: 2 (тэмцээний эхний өдөр сонгон шалгаруулах дасгал 2 төрлийн буугаар буудлага хийнэ. Дасгалыг 3 удаа гүйцэтгэж болох ба хамгийн өндөр нэг дүнг урьдчилсан шалгаруулалтын дүн болгоно. Шалгарсан 8 удирдлага тэмцээний 2 дахь өдөр 2 төрлийн буугаар халз буудлага хийж аварга тодорно.

Сумын тоо, хэмжээ: Эхний өдөр гар бууны сум 36, шотганы сум 18, халз буудлагад гар бууны сум 36 ширхэг, шотганы сум 24 ширхэг;

Баг: 1 тамирчнаас бүрдэнэ;

Багийн дүн гарах эсэх: Үгүй;

4. Гурван буу/3 Gun-Тусгай томилгоот бүлэг

Огноо: Тэмцээний 2 дугаар өдөр;

Ангилал: Тактикал Оптикс/Тас Ops, Карабин 1 таталттай оптик харааны хэрэглэлтэй, хөл хэрэглэхгүй, гар буу болон шотган ил харааны хэрэгсэлтэй, холын буудлагын винтов буу гар цэнэглэлтэй, дурантай зэвсэг байх ба буудагч тусгай ажиллагааны хувцас, хэрэглэлтэй байна;

Төрөл: 2 ба 3 буу;

Шаардлага: Тусгай томилгоот нэгжийн албан хаагчид оролцоно;

Дасгалын тоо: 6

Сумын тоо, хэмжээ: Нийт багаар 9x19 мм-ийн 304 ширхэг, .223 rem 112 ширхэг, шотган сум 24 ширхэг, винтов сум 10 ширхэг, 7.62 мм дээш калибрын сум ашиглахгүй. Сумын тоо бага хэмжээгээр өөрчлөгдөх магадлалтай.

Баг: Тусгай томилгоот нэгжийн 4 албан хаагч оролцоно;

Багийн дүн гарах эсэх: Тийм;

Байгууллагын багийн нэгдсэн дүнд харгалзах: Хамаарахгүй. Харин тусгай томилгоот бүлгийн нэгдсэн байр эзлүүлж, цомын аваргыг шалгаруулна.

Тэмцээний бүртгэл: 2026 оны 08 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл www.asianshooting.academy хаягаар хүлээн авна.

Тэмцээний дүн гаргах:

Багийн нэгдсэн дүнг тусгай томилгоот нэгжийн албан хаагчдаас бусад албан хаагчдын тэмцээний төрөлд харгалзах онооны зарчмаар тооцож байр эзлүүлэх бөгөөд оноолтын зарчмыг техникийн зөвлөгөөн дээр зарлана.

Байгууллага бүрийн хөндлөнгийн шүүгч тэмцээний төгсгөлд байгууллагынхаа нэрийн өмнөөс баг, тамирчдаа төлөөлөн тэмцээний нийт дүнтэй танилцан зөвшөөрч гарын үсэг зурна.

Тэмцээний эцсийн дүнг нягтлан эцэслэх:

Тэмцээний ерөнхий шүүгч, талбайн шүүгч, хөндлөнгийн шүүгчид бүгд байлцан тэмцээний нэгдсэн дүнтэй танилцана.

Тэмцээний дүнгийн бүртгэл дээр хийсэн засваруудтай танилцаж, тайлбарыг сонсон эцэслэн шийдвэрлэнэ.

Маргаан шийдвэрлэх:

Буудагч гомдол гаргавал ерөнхий шүүгч, тухайн дасгалын талбайн болон хөндлөнгийн шүүгч нар байлцан гомдлыг тухай бүр шийдвэрлэнэ. Шийдвэр гаргахдаа дүрс бичлэг болон гэрчүүдийн тайлбарыг үндэслэн дүгнэлт гаргана. Шийдвэр эцсийнх байна.

ХОЁР. ШАГНАЛ

Шагнал, урамшуулал: Тамирчдын дүнг төрөл тус бүрээр хувийн болон багийн дүнгээр гаргаж, нэгдсэн байр эзлүүлнэ.

Хувийн дүнгээр (гар буу, карабин, цэц буудлага болон удирдлага):

1-р байр: Өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйл

2-р байр: Өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйл

3-р байр: Өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйл

Багийн дүнгээр (гар буу, карабин):

1-р байр: Өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйл

2-р байр: Өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйл

3-р байр: Өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйл

Нэгдсэн багийн дүнгээр (гар буу, карабин, цэц буудлага болон удирдлага):

1-р байр: Шилжин явах цом, өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйл

2-р байр: Батламж, өргөмжлөл, үнэ бүхий зүйл

3-р байр: Батламж, өргөмжлөл, үнэ бүхий зүйл

Тусгай томилгоот бүлгийн багийн дүнгээр:

1-р байр: Шилжин явах цом, өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйл

2-р байр: Батламж, өргөмжлөл, үнэ бүхий зүйл

3-р байр: Батламж, өргөмжлөл, үнэ бүхий зүйл

ГУРАВ. ХУВААРЬ

Тэмцээний эхний өдөр:

09:00-17:00 Гар буу, карабин, цэц буудлага болон удирдлагын тэмцээн;

12:00-12:30 Тэмцээний нээлт.

Тэмцээний хоёрдугаар өдөр

09:00-16:00 Тусгай томилгоот нэгжийн буудлага;

14:00-16:00 Удирдлагын халз буудлагын тэмцээн;

17:00-18:00 Тэмцээний хаалт.

ДӨРӨВ. ХОЛБОО БАРИХ

Тэмцээн зохион байгуулагчид:

Азийн буудлагын академи, Монголын Гурван бууны болон Төмөр буудлагын холбоо;

Захирал: П.ЭРДЭНЭБИЛЭГ;

Утас: 99117696;

Дотоод хэргийн их сургуулийн тэмцээн зохион байгуулах ажлын хэсэг

Б.БОЛД-ЭРДЭНЭ, Б.НОМИН;

Утас: 99099724, 99089288

Тэмцээний ерөнхий шүүгч:

Ханан ар буудлага спорт, сургалтын төв;

Захирал М.БАЯРСАЙХАН; Утас: 94004774

ТАВ.СУМ, ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ

- ✓ Ган зүрхэвчтэй, шатаагч болон гэрэлтэгч сум (цэрэг, цагдаагийн) ашиглахыг хориглоно. Тэмцээнд 300win mag, 308 win, 30-06 калибраас дээш сум хэрэглүүлэхгүй;
- ✓ Аливаа сум хэрэгслийг Шүүгч аюултай гэж үзвэл, тэмцээнд ашиглахыг зөвшөөрөхгүй;
- ✓ Гар бууг суганд зүүхийг хориглоно;
- ✓ Тусгай томилгоот нэгжийн албан хаагчдаас бусад тамирчид гар бууг зөвхөн ташаанд зүүнэ;
- ✓ Гар бууны гэр бүс нь өмдний 3-аас доошгүй гогцоонд найдвартай бэхлэгдсэн байна;
- ✓ Гэрт хийсэн гар бууны гол төмрийн чиглэл буудагчийн хөлнөөс 1 метрээс ихгүй байна;
- ✓ Буудагчид албаны болон спортын тактик хувцас, чихэвч, нүдний шилтэй дасгал гүйцэтгэнэ.

ЗУРГАА. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА

- ✓ Тэмцээнийг явуулахад аюулгүй ажиллагааны журмыг чанд сахина;
 - ✓ Оролцогч тамирчид ба үзэгчдээс аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг биелүүлээгүй тохиолдолд тэмцээний талбайгаас гаргана;
 - ✓ Аливаа галт зэвсэгтэй үргэлж цэнэгтэй гэж болгоомжлон харьцана;
 - ✓ Галт зэвсэг буудлага үйлдэхээс бусад тохиолдолд үргэлж цэнэггүй байна;
 - ✓ Буудлага үйлдэхээс бусад үед гох дээр хуруу тавихгүй;
 - ✓ Зэвсгийн хошуу байнга аюулгүй зүгт, буудлагын үед бай руу чиглүүлнэ;
 - ✓ Буудлага үйлдэхдээ бай болон эргэн тойрноо байнга хянаж эрсдэлээс сэргийлнэ;
 - ✓ Буудлагын талбайд байгаа бүх буудагч нарын гар буу бууны гэрт магазин угсраагүй, цэнэггүй байдалтай байна;
 - ✓ Буудлагын талбайд байгаа хүн бүр хамгаалалтын нүдний шил, чихэвчийг байнга зүүнэ;
 - ✓ Шүүгчийн зөвшөөрөлгүйгээр бууг гэрнээс гаргах, магазин угсрахыг хориглоно. Буутай харьцах бүх үйлдэл нь зөвхөн шүүгчийн командаар галын шугам дээр эсвэл "аюулгүйн бүс" дээр хийгдэнэ;
 - ✓ "Аюулгүйн бүс" гэдэг нь тухайн буудлагын талбайд аюулгүй зүгт хуурай дасгал хийх, бууг задалж угсрах, тослох, засвар үйлчилгээ хийх зэрэг буудахаас бусад үйлдэл хийхийг зөвшөөрсөн газрыг хэлнэ.
- "АЮУЛГҮЙН БҮС"-д хориглох зүйл:**
- ✓ Сум бүхий магазинд гар хүрэх, сум болон түүнтэй ижил төстэй загварын сум хэрэгслийг гарт барих, буунд сумтай магазин угсрахыг хориглоно;
 - ✓ Буудагч галын шугамнаас бусад газарт бууг санамсаргүй унагаасан тохиолдолд тэмцээнээс хасагдах арга хэмжээ авагдахгүй ба бууг газраас өөрөө авахыг хориглоно. Талбайн шүүгч унасан бууг газраас авахдаа оролцогч болон үзэгчдийг холдуулж, бууны амыг аюулгүй зүгт харуулан авна;
 - ✓ Магазиныг буудлагын талбайн аль ч хэсэгт сумлаж болно.

Тэмцээнээс хасах:

- ✓ Дасгалыг гүйцэтгэх явцад буудлагын аюулгүйн өнцөг эвдсэн;
- ✓ Дасгалыг гүйцэтгэх шилжилт хөдөлгөөний үед гох дээр хуруу тавьсан.
- ✓ Дасгал гүйцэтгэх үед зүй бус үг хэллэг хэрэглэсэн буюу спортын бус байдлаар биеэ авч явсан.
- ✓ Галын шугамаас гадна зэвсэгт магазиныг угсарсан.

ДОЛОО. БУСАД

- ✓ Тэмцээнд оролцогч нь зарлагдсан хугацаанд багтан бүртгүүлнэ;
- ✓ Бүртгэлд орсон буудагч нарыг бүлэг болгон хуваана;
- ✓ Дасгал гүйцэтгэх буудагч нь зөвхөн талбайн шүүгчийн командаар бууг гаргаж цэнэглэнэ;
- ✓ Тэмцээний төрөл бүрд эхний 3 буудагчийг шалгаруулна;
- ✓ Дасгалыг гүйцэтгэх буудагч нь галын шугам дээр талбайн шүүгчийн "бууг цэнэглэж бэлдэнэ үү" командаар бууг гэр савнаас гарган цэнэглээд, дасгалын заагдсан нөхцөлөөр бэлэн байдалд орно;
- ✓ Дараагийн "бэлэн үү" командын хариуд буудагч "Бэлэн" гэж хэлэх, эсхүл толгой дохих, чимээгүй байдлаар дасгалыг гүйцэтгэхэд бэлэн гэдгийг илтгэнэ;
- ✓ Шүүгч "АНХААР" команд өгч, 1-4 секундйн дараа дуут дохио дугарснаар дасгалыг эхлэх хугацаа явж, сүүлчийн буудалтаар хугацаа зогсоно;
- ✓ Дасгал гүйцэтгэсний дараа шүүгчийн "Хэрэв буудаж дууссан бол бууг шалгаж аюулгүй болгоод харуулна уу" командаар цэнэггүй болгосон бууг шүүгчид харуулан дараагийн "Хяналтын буудлага, БУУ ГЭРТ" командаар буудагч нь аюулгүй байдлыг сахин аюулгүй болгосон бууг гэр саванд хийнэ;
- ✓ Шүүгчийн "байг шалга" командаар бай руу явна;
- ✓ Шүүгч нар байг шалгаж, алдаа оноог тэмдэглэнэ;
- ✓ Буудагч өөрийн оноо үнэн зөв бөглөгдсөн эсэхийг нягтлаад, гарын үсгээр баталгаажуулна;

ХЯНАСАН:

АЗИЙН БУУДЛАГЫН АКАДЕМИ, МОНГОЛЫН ГУРВАН БУУНЫ БОЛОН
ТӨМӨР БУУДЛАГЫН ХОЛБООНЫ ЗАХИРАЛ П.ЭРДЭНЭБИЛЭГ

САНХҮҮ, АР ТАЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Б.БОЛД-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:

ШИНЖЛЭН МАГАДЛАХ УХААНЫ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Б.НОМИН

